

**ХӨСӨГ ТРЕЙД ХК-ийн
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ**

2021 оны 11 сар 06 өдөр

Дугаар 9

Улаанбаатар хот

ХЭЛЭЛЦСЭН НЬ:

“ХӨСӨГ ТРЕЙД” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал 2021 оны 11 дүгээр сарын 06-ний өдрийн 12.00 минутанд Улаанбаатар хот, Баянгол дүүргийн 20-р хороо, Эрчим хүчний гудамж компанийн өөрийн байранд болов.

Хуралд : Д.Нямбаяр 89,618 ширхэг хувьцааны саналаар /өөрийн биеэр/
Л.Цэгмид 51,830 ширхэг хувьцааны саналаар /өөрийн биеэр/
Л.Мягмаржав 3,870 ширхэг хувьцааны саналаар /өөрийн биеэр/
Д.Сугаржав 1,459 ширхэг хувьцааны саналаар /өөрийн биеэр/
“Эм Ди Эм Эм Ди” ХХК-ийг төлөөлж Б.Анхбаяр 96,357 ширхэг хувьцааны саналаар /төлөөл/
Д.Халтар 44,824 ширхэг хувьцааны саналаар /өөрийн биеэр/
287,958 ширхэг хувьцаа буюу нийт гаргасан хувьцааны 97.3% хувийг эзэмшигчид хуралд оролцлоо.

Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хараат бус гишүүд болох Б.Төрсайхан, С.Мөнхгэрэл, ердийн гишүүн Д.Бямбажал нар хуралд байлцав.

Хурлыг компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дарга Л.Мягмаржав удирдав.

Хурлаар:

- Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийн бүрэн эрхийг дуусгавар болгож, шинээр томилох тухай;
- Компанийн 2021 оны хагас жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлах;

асуудлыг тус тус хэлэлцэв.

Л.Мягмаржав: Тооллогын комисс ирцээ гаргасан бол танилцуулья. Хурал хүчин төгөлдөр болох ирц хүрсэн бол хурлаа эхэлье.

Тооллогын комиссын дарга Б.Эрдэнэтуяа хурлын ирцийг танилцуулан, Тооллогын комиссын анхны тогтоолыг уншиж танилцуулав.

Тооллогын комиссын тогтоолоос үзэхэд хурлын ирц 97.3% хувьтай байгаа тул Монголын Улсын компанийн тухай хуулийн 69.1 д заасны дагуу хурлын ирцийг хүчин төгөлдөрт тооцож, хурлыг эхлүүлэх зөвшөөрлийг хурлын даргад өгөв.

-Хувьцаа эзэмшигч Б.Анхбаяр: Шаардлагыг хангаж байгааг мэдээлж, нэр дэвшигчдийг танилцуулав.

Нэр дэвшигчдээс асуух асуулт байхгүй тул хурлаар хэлэлцэх асуудал дуусав.

- Хурлын дарга Л.Мягмаржав: Асуух зүйлгүй бол хувьцаа эзэмшигчид хурлын материалд тараасан саналын хуудсаар саналаа өгөөд, тооллогын комисс ажлаа хийх хугацаанд хурлыг түр завсарлая. Шинэ хувьцаа эзэмшигчийн төлөөлөл та бүхэн тооллогын комиссын ажилд давхар хяналт тавьж болно шүү.

Хэлэлцүүлсэн асуудлуудын талаарх санал авах саналын хуудсыг тарааж бөглүүлэв.

Тооллогын комисс саналаа хурааж тоолж дүнгээ гаргаж уншиж танилцуулав.

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

1. Компанийн хувьцаа эзэмшигчдийн 2021 оны ээлжит бус бус хурлын хэлэлцэх асуудлын нэгдүгээрт тусгагдсан Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийн бүрэн эрхийг хугацаанаас нь өмнө дуусгавар болгох асуудлаар хуралд оролцсон саналын эрхтэй гишүүдийн ... хувь нь "дэмжсэн", ... хувь нь "татгалзсан" санал өгсөн буюу олонх нь дэмжээгүй тул Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийн бүрэн эрхийг хугацаанаас нь өмнө дуусгавар болгохоос татгалзсугай.
2. Компанийн хувьцаа эзэмшигч Эм Ди Эм Эм Ди ХХК-ийг төлөөлж, өмнө нь ТУЗ-ийн бүрэлдэхүүнд томилогдсон гишүүдээс үүргээ биелүүлэх боломжгүй болсон ба чөлөөлөгдөх тухай хүсэлтээ ирүүлсэн нөхцөлд Компанийн тухай хуульд заасны дагуу ТУЗ-өөс Эм Ди Эм Эм Ди ХХК-иас санал болгосноор тухай бүр орны хүнийг нь томилох боломжтойг дурдсугай.
3. Компанийн 2021 оны хагас жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлантай танилцсанаар тайланг баталсугай.

Хэлэлцэх асуудал дууссан тул хурал 13 цаг 50 минутад өндөрлөв.

ХУРЛЫН ДАРГА:

Л.МЯГМАРЖАВ

ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН:

А.АРИУНСАЙН